



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/200

Өмнөдэлгэр сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Гурванбаян тосгоны Соёлын төв (9076255)-ийн газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг хавсралтаар сунгасугай.
2. Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, Газрын тухай хууль болон гэрээний дагуу эзэмшихийг газар эзэмшигч Өмнөдэлгэр сумын Гурванбаян тосгоны Соёлын төвийн эрхлэгч Чулуунбаатарын Ононцэцэгт даалгасугай.
3. Газар эзэмшилтэнд байнгын хяналт тавьж, газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг сумын Газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2004 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 27 дугаар захирамжийн Өмнөдэлгэр сумын Гурванбаян тосгоны Соёлын төвд холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



D:\disk\bichig hereg/ zahiramj/

2326310400



сумын Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 11-ний өдрийн
А/200 дугаар захирамжийн хавсралт

№	Хуулийн этгээдийн нэр	Регисрийн дугаар	Газрын зориулалт	Эзэмшүүлэх хугацаа /жил/	Газрын нэр	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ /м2/
1	Өмнөдэлгэр сумын Гурванбаян тосгоны Соёлын төв	9076255	Урлаг, соёлын байгууллага	40	7 дугаар баг, Жавхлант 1 дүгээр гудамж, 137 тоот	2314001662	1218
Дүн							1218